

# Номлогчийн үйлчлэлийн адислал

Дараах судрын хэсгүүд болон мэдэгдлүүдийг судал. Судалж байхдаа дараах зүйлсийг олж мэд. Үүнд:

1. Бидний номлолын хүчин чармайлтаар дамжуулан Их Эзэний бусдад өгч болох адислал.
2. Номлолд үйлчилсний төлөө Их Эзэний бидэнд өгч болох адислал.

Сургаал ба Гэрээнүүд 4:1–4

Сургаал ба Гэрээнүүд 15:6

Сургаал ба Гэрээнүүд 18:14–16

Сургаал ба Гэрээнүүд 31:3–8

Сургаал ба Гэрээнүүд 50:22

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн заасан.



Ах, эгч нар аа, Есүс Христийн сайн мэдээ урьд өмнөхөөс ч илүү хэрэгтэй байна. Зөрчилдөөн Аврагчийн төлөөлж, зааж байсан бүхэнтэй харшилдаг. Би Их Эзэн Есүс Христэд хайртай бөгөөд Түүний сайн мэдээ бол амар амгаланд хүргэх *цорын ганц* найдвартай шийдэл гэдгийг гэрчилж байна. Түүний сайн мэдээ бол амар амгалангийн сайн мэдээ юм [Сургаал ба Гэрээнүүд 27:16-г үзнэ үү]. . . .

Бүх номлогч Аврагчийн тухай зааж, гэрчилдэг. Дэлхий дээр сүнслэг харанхуй нэмэгдэх тусам Есүс Христийн гэрэл бүр илүү шаардлагатай болж байна. Хүн бүр Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар мэдэж авах боломжийг хүртэх эрхтэй. Хүн бүр “бүх оюун ухааныг [давах]” [Филиппой 4:7] найдвар, амар амгаланг хаанаас олж болохыг мэдэх эрхтэй. (Рассэлл М.Нэлсон, “Амар амгалангийн сайн мэдээг номлох нь,” *Лиахона*, 2022 оны 5-р сар, 6–7)

Далын ахлагч Маркус Б.Нэш ийн заасан.



Сайн мэдээг хуваалцах нь хуваалцаж байгаа, хүлээн авч байгаа хоёр хүний аль алинд баяр хөөр, итгэл найдвар төрүүлдэг. Сайн мэдээг хуваалцахад үнэхээр “та нарын баяр хөөр хэчнээн агуу байх билээ!” [Сургаал ба Гэрээ 18:15]. Сайн мэдээг хуваалцах нь баяр хөөрийн дээд баяр хөөр, найдварын дээд найдвар юм. . . .

Сайн мэдээний гэрлийг өргөхгүй байхыг сонгох нь биднийг сүүдэр лүү хөтөлдөг бөгөөд тэнд бид уруу татагддаг. Чухамдаа эсрэгээрээ, сайн мэдээний гэрлийг өргөхийг сонгох нь биднийг тэрхүү гэрэлд мөн уруу таталтаас хамгаалах хамгаалалтад илүү бүрэн дүүрэн оруулдаг нь чухал шүү. Өнөөгийн дэлхийд энэ нь ямар агуу адислал вэ! (Маркус Б.Нэш, “Гэрлээ өргө,” *Лиахона*, 2021 оны 11-р сар, 6–7)